

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Өдрийн тэмдэглэл бичихийн ач тус:

- Тухайн үйл явдалд хандах хандлага, мэдрэмж, сэтгэл хөдлөлөө илэрхийлж сурна.
- Өөрийнхөө хувьсал өөрчлөлтийг мэдэрнэ.
- Хойч үедээ амьдралын туршлагаа өвлүүлнэ.
- Дурсамжаа сэргээнэ.

Дасгал 4. Хэлц үг ашиглан, өдрийн тэмдэглэл бичээрэй.

Алхам 1. Тохиолдсон явдлаа сонгоорой. Сонголтын өмнөх нүдэнд + тэмдэг тавиарай.

	Баяртай үйл явдал		Жаргалтай байсан үйл явдал		Уйтгар, гунигтай үйл явдал
	Сэтгэл амраасан үйл явдал		Айж түгшсэн үйл явдал		Уурлаж, бухимдуулсан үйл явдал

Алхам 2. Сонгосон үйл явдалдаа тохируулан дараах хэлц үгээс ашиглаарай.

Баяртай	Хөл газар хүрэхгүй, магнай тэнийх, аз шовойх, амны хишигтэй, нүүр дүүрэн, хөл хөнгөрөх, тэнгэрээс од шүүрэх	Жаргалтай	сэтгэл дүүрэх, элэг зүрхний угаас, хөл хөөрцөг болох, шавай ханах, нүүр баатар, сэтгэл онгойх	Уйтгартай	Сэтгэл гундуу, элэг эмтрэх, сэтгэл хоосрох, зүрх шимшрэх, гол гонсойх, толгой ганзагалах, нүд хуурайгүй, уруу царайлах
Сэтгэл амраасан	Айдгийгаа авдартаа хийх, амьсгаа авах, зоо тэнийх, чих амрах, сэтгэл амрах, цээж тэнийх, яс амрах, элэг дэвтэх	Айж түгшсэн	Сүнс зайлах, нуруугаар хүйт даах, зүрх чичрэх, зүрх алдах, алийгаа алдах, амьтан болох, толгойтой үс босох	Уурласан	Аагаа багтааж ядах, уур буцлах, цес ихтэй, дээлэндээ багтахгүй, галзуурахад ганц хуруу дутуу, хор шар буцлах, хөмсөг зангидах

Алхам 3. Үйл явдлаа дараах бүтцийн дагуу бичээрэй.

_____	Огноо, тухайн үеийн нөхцөл байдал, сэтгэл хөдлөл
_____	Болсон хэрэг явдлын дүрслэл түүний талаарх бичигчийн сэтгэл хөдлөл, сэтгэгдэл мэдрэмж

_____	Хэрэг явдлын дүгнэлт, бичигчийн бодол, бичигчийн нэр

Дууссан:онсарөдөр